

**“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН”
ОНӨААТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО
/2025-2030 ОН/**

Дархан-Уул аймаг
Дархан сум
2025

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Хүний нөөцийн стратегийн зорилго
- 1.2 Хүний нөөцийн стратегийн хамрах хүрээ
- 1.3 Хүний нөөцийн стратегийн хэрэгжих хугацаа

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

- 2.1 Зохион байгуулалтын бүтэц, орон тоо
- 2.2 Хүний нөөцийн судалгаа
- 2.3 Хүний нөөцийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- 2.4 Хүний нөөцийг сургаж, хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- 2.5 Хүний нөөцийн мэдээллийн системийн өнөөгийн байдал

ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЦААШДЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

- 3.1 Хүний нөөцийн 2030 он хүртэлх хэрэгцээ шаардлага
- 3.2 Хүний нөөцийн удирдлагын SWOT шинжилгээ
- 3.3 Хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдлын дүгнэлт

ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ХҮРЭХ ҮР ДҮН

- 4.1 Хүний нөөцийн стратегийн зорилго
- 4.2 Хүний нөөцийн стратегийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

ТАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

- 5.1 Стратегийн баримт бичгийн хэрэгжилт
- 5.2 Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү бодлогын баримт бичиг нь байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ.

1.1 Хүний нөөцийн стратегийн зорилго: “Дархан хотын соёл амралтын хүрээлэн”ОНӨААТҮГ-ын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, сонгон шалгаруулах, бүрдүүлэх, бэлтгэх, хуваарилах, хүний нөөцийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бэлэн байгаа хүний нөөцийг үнэлэх, оновчтой байршуулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож, байгууллага, салбарын тогтвортой хөгжлийг хангахад оршино.

1.2 Хөтөлбөрийн хамрах хүрээ: Энэхүү хөтөлбөр нь “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн”ОНӨААТҮГ-ын хүний нөөцийг сургах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах, давтан сургах болон шинээр мэргэжил эзэмшсэн ажилтан дадлагажуулах сургах үйл ажиллагааг хамаарна.

1.3 Хүний нөөцийн стратегийн хэрэгжих хугацаа: Хүний нөөцийн стратеги нь 2025-2030 он хүртэл хэрэгжинэ.

1.4 Хүний нөөцийн бодлогын баримтлах үндсэн зарчим: Байгууллагын эрхэм зорилгод нийцүүлэн тасралтгүй үйл ажиллагааг хангах, ажилтанд чиглэсэн үйл ажиллагааг явуулахын тулд дараах үндсэн зарчимуудыг баримталж ажиллана. Үүнд:

- 1.4.1 Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээг нийт ажилтнууддаа нээлттэй танилцуулж, хөдөлмөрийн харилцааны холбогдох хуулиудыг чанд баримталж ажиллах
- 1.4.2 Ажилтануудыг байнгын сургалтанд хамруулж, үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах ур чадварыг эзэмшүүлэх
- 1.4.3 Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, таагүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, нэгэнт үүссэн зөрчлийг даруй арилгах арга хэмжээг авч ажиллах
- 1.4.4 Мэргэжлээрээ өсөж хөгжих боломжийг олгож, чадварлаг боловсон хүчнээ дотоод эх үүсвэрээс дэвшүүлэн ажиллуулах, сонгон шалгаруулж, мэргэшсэн ажилтан бэлдэхийг зорих
- 1.4.5 Ажил үүргээ гүйцэтгэхэд аюул осол багатай, ажиллах таатай орчин нөхцөл бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангаж ажиллах
- 1.4.6 Байгууллагын өөрчлөлт, стратеги төлөвлөгөөнд тавигдсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх,
- 1.4.7 Ажилтануудыг байнгын сургалтанд хамруулж, үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах ур чадварыг эзэмшүүлэх

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 Зохион байгуулалтын бүтэц, орон тоо: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь заалтыг үндэслэн Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн №15 тогтоолоор байгуулагдсан. Анх 39 орон тоотойгоор байгуулагдаж байсан бол 2025 оны байдлаар 29 албан тушаал дээр 55 орон тоотойгоор ажиллаж байна. “Дархан хотын соёл амралтын хүрээлэн”ОНӨААТҮГ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад холбоотой хуулиар олгогдсон эрхийн дагуу зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн”ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмыг удирдлага болгон ажилладаг бөгөөд

1. Захиргаа, удирдлагын хэлтэс,
2. Санхүүгийн алба,
3. Тохижилт үйлчилгээний алба,
4. Ногоон байгууламжийн алба
5. Арчлалт хамгаалалтын алба гэсэн зохион байгууллагатайгар үйл ажиллагаа явуулж байна.

"Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ нь дараах үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхийг байгууллагын дүрэмд заасан байдаг.

- Хөдөлгөөнт тоглоом болон бусад үйлчилгээг хариуцах;
- Үйлчилгээний чанар стандарт, аюулгүй байдлыг хангуулах;
- Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, засвар үйлчилгээгхариуцах;
- Нийтийн эзэмшлийн талбайд хуулийн хүрээнд нийтийг хамарсан соёл олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөлөөр хангах;
- Аливаа үйл ажиллагааг явуулахдаа хөдөлгөөнт тоглоомоор иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан жишиг унийг баримталж ажиллах;
- Ногоон байгууламжийн арчилгаа, тордолт, хамгаалалт, нөхөн тайралтыг хариуцах;
- Хөшөө, дурсгал, чимэглэлийг арчлах;

- Явган хүний зам арчлах;
- Соёл амралтын хүрээлэнгийн эзэмшлийн талбайн тэмдэг, тэмдэглэгээ, сандал, хогийн сав, явган хайсны ашиглалт засварыг хариуцах;
- Хариуцсан техник хэрэгсэл, машин механизм, тоног
- Төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх;
- Нийтийн эзэмшлийн талбайд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хяналт тавих;
- Газар нь тусгай зөвшөөрөлд шаардагдах үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр эрхлэх;

Мөн түүнчлэн:

- Газар нь байгууллагын чадавхыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, нийтийн эзэмшлийн эд аж ахуйг засварлах, шинэчлэх, нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллах;
- Газар нь тусгай зориулалтын шинэ техник технологийг нэвтрүүлэх, хүчин чадлыг нь бүрэн ашигласан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг зорих;
- Газар нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Газар нь төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифийг тогтоохдоо Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Сумын Засаг Даргын тамгын газар, Засаг даргын ажлын албанаас баталсан дүрэм журмыг мөрдөх;
- Газар нь өөрийн үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас батласан жишиг үнийн нормативийг баримталж ажиллах;
- Газар нь орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, авто зам, барилга байгууламж, эд аж ахуйг шинээр барих, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад хүлээн авахад оролцож, саналаа илэрхийлэн, баримт бичигт холбогдох этгээд гарын үсэг зурах;
- Газар нь өөрийн эрхлэх үндсэн үйл ажиллагааг өмчийн бүх төрлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх

2.2. Хүний нөөцийн судалгаа: Зохион байгуулалтын бүтэц, орон тооны дагуу Захиргаа удирдлагын хэлтэс-7, Санхүүгийн алба-5, Тохижилт үйлчилгээний алба-16, Ногоон байгууламжийн албар-6, Арчлалт хамгаалалтын алба-21 нийт 55 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 2025 оны 03 дугаар сарын байдлаар нийт 50 ажилтан ажиллаж байгаа бөгөөд сул орон тоо 5 байна. Хүүхэд асрах чөлөөтэй, захиргааны болон бусад чөлөөтэй хүн байхгүй. Нийт ажиллагсдын 24 хувь нь эмэгтэй ажилтан, 76 хувь нь эрэгтэй ажилтан ажиллаж байна.